



БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248 дугаарын утаснаас лавлана уу?

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
өрөөний утас 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
өрөөний утас 70273465

Шинжээч
Ц.Хишигжаргал
Өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Баян-Өнжүүл сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Баян-Өнжүүл сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Баян-Өнжүүл сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 43302.30 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 38439.0 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 4863.3 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар дутуу биелүүлсэн байна.
- Орон нутгийн төсвөөс 5217.2 мянган төгрөгийг ОНХСанд ИТХурлын тогтоол шийдвэргүйгээр шилжүүлэн зарцуулсан байна
- Орон нутгийн хөгжлийн сангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй 13440.6 мянган төгрөгийг сумын Засаг даргын захирамжаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материалын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудитор санал хүргүүлсэн байгаа.

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.24-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.24

Танилцуулга

Баян-Өнжүүл сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Баян-Өнжүүл сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Баян-Өнжүүл сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Баян-Өнжүүл сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Баян-Өнжүүл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны 12-р сарын 19-ний өдрийн 02-р хуралдааны 01-р тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 43302.30 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 38439.0 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 4863.3 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар дутуу биелүүлсэн байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 64068.3 мянган төгрөг, гүйцэтгэлээр 66600.5 мянган төгрөг буюу биелэлт 104 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 1400.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1578.7 мянган төгрөг биелэлт 112.8 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 12123.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 38439.0 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 208213.0 мянган төгрөг, нийт 246652.0 мянган төгрөг төвлөрч, санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 143896.4 мянган төгрөг, ИТХУралд 34795.2 мянган төгрөг, Багт 29521.4 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс ЗДТГазарт 46361.6 мянган төгрөг буюу нийт 254574.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл 4899.7 мянган төгрөг нь ОНОрлогын харилцах дансанд байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 288665.0 мянган төгрөг, Цэцэрлэгт 113577.8 мянган төгрөг, Эмнэлэгт 189524.2 мянган төгрөг, Соёлын төвд 47100.2 мянган төгрөг нийт 638867.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. Дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 3998.4 мянган төгрөгийг, НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 1770.7 мянган төгрөгийг болон оны эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 12.3 мянган төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 138498.1 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 107043.1 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 27840.0 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 2930.0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 24418.9 мянган төгрөг, Сургууль 1803.0 мянган төгрөг, ЭМТөв 107.0 мянган төгрөг нийт 26328.9 мянган төгрөгийн орлого, 21028.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 5300.4 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 1059.2 мянган төгрөг, Соёлын төв 593.7 мянган төгрөг, Сургууль 1023.0 мянган төгрөг, нийт 2675.9 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн санд 156894.2 мянган төгрөг, Сум хөгжүүлэх санд 50000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн ХЭДСангийн данснаас төвлөрсөн сумын төрийн сангаар гүйлгээ хийгдээгүй байна

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 75059.7 мянган төгрөг дээр 1197810.6 мянган төгрөгийн орлого төвлөрч 1169507.5 мянган төгрөгийг зарцуулж 103362.9 мянган төгрөг үлдсэн байна. 2013 оны эхэнд ЗДТГазар 0.5 мянган төгрөг, ИТХурал 41.0 мянган төгрөг, Баг 1729.1 мянган төгрөг нийт 1770.6 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 60028.5 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 12123.5 мянган төгрөг, эм эргэлтийн сан 1137.0 мянган төгрөг нийт 75092.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 92633.3 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 4899.7 мянган төгрөг, эм эргэлтийн сан 7453.7 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 2939.3 нийт 151511.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 1249.5 мянган төгрөгийн авлага, оны эцэст 54893.6 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 53644.1 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 54799.0 мянган төгрөгийн буюу 98.8 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Өглөгө оны эхэнд 1506.0 мянган төгрөг, оны эцэст 1495.7 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцэст ЭМТөвийн шатахууны өглөг 542.8 мянган төгрөг, түлш халаалт 231.6 мянган төгрөг нийт 774.4 мянган төгрөг нь өглөгийн 52 хувийг эзэлж байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 130389.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 156597.1 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж,

148021.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 131965.0 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 3568960.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 675915.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 504277.8 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 3740597.9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 134952.1 мянган төгрөг үлдэх өртөг 3012984.1 мянган төгрөг байна

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 6 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Тус сангийн харилцах данс нь оны эхний үлдэгдэл 537.1 мянган төгрөг байснаас тайлант онд 11030.7 мянган төгрөгний орлого төвлөрч 8456.4 мянган төгрөг зарцуулж дансанд 3111.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар бүрдүүлсэн байна. Үүнд: Аймгаас байгаль орчныг хамгаалах ажилд 9000.0 мянган төгрөг, иргэдээс усны хураамж 1417.0 мянган төгрөг, аж ахуйн нэгжүүд усны төлбөрт 410.3 мянган төгрөг, биотехникийн арга хэмжээ 180.0 мянган төгрөг нийт 11030.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2013 онд аймгийн төсвөөс 12000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирүүлснээс батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд: Худаг ажиллуулсаны урамшуулалд 1810.4 мянган төгрөг, кантер машины засварт 400.0 мянган төгрөг, Хог ачиж буулгасны зардалд 360.0 мянган төгрөг, булгийн эх хамгаалахад 2750.0 мянган төгрөг, худгийн засварт 2136.0 мянган төгрөг, эргүүл хяналтын шатахуунд 1000.0 мянган төгрөг нийт 8456.4 мянган төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн санд тайланд онд 203194.2 мянган төгрөгийн орлого, 121361.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст харилцах дансанд 81832.6 мянган төгрөгний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Орлогыг тодруулахад улсын төсвийн санхүүжилт 156894.2 мянган төгрөг, Эрдэнэ жас ХХК хандив 3000.0 мянган төгрөг, Мегамайнз ХХК 3000.0 мянган төгрөг, Хаан банк 300.0 мянган төгрөг нийт 6300.0 мянган төгрөгийн хандив, ТАХ-дын байрны санхүүжилт 40000.0 мянган төгрөг нийт 203194.2 мянган төгрөг төвлөрсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх Хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтыг сумын ИТХурлын -р хуралдаанаар 2013 оны –р сарын -ний өдрийн тоот тогтоолоор төсөл хөтөлбөрт мянган төгрөгөөр баталсан.

Тайлант онд ОНХСангийн санхүүжилтэнд 156894.2 мянган төгрөгийг олгосон СТСХэлтсээс ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 15894.1 мянган төгрөг буюу 0.1 мянган төгрөг зөрүүтэй байна. Хөрөнгө оруулалтын хийгдсэн ажлыг тодруулахад:

Эмнэлгийн барилгын инженер хайгуулын зурагны үнэ буурь хөрс ХХК-д 1651.7 мянган төгрөг, эмнэлгийн барилгын байр зүйн зураг Бэйс пойнт ХХК 200.0 мянган төгрөг, Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж Чиглэл ХХК 4110.0 мянган төгрөг, төв саадны тохижилт Мон авзага хайрхан ХХК-д 36728.5 мянган төгрөг, Бэлчээрийн худаг 3 ширхэг газрын гүний ус ХХК-д 42198.2 мянган төгрөг, Соёлын төвийн тоног төхөөрөмж Октава ХХК

–д 2202.2 мянган төгрөг, дотуур байрны сурагчын орны үнэ мандах хөргөлт ХХК 3750.0 мянган төгрөг, гудамжны гэрэлтүүлэг Зуунмод түгээх төв-д 13000.7 мянган төгрөг, баяр наадмын зардалд 11500.0 мянган төгрөг, 3-н ширхэг асар Хааны асар ХХК-д 1800.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

ОНХСангаас ард иргэдийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтад ороогүй дараахь гүйлгээг сумын Засаг даргын захирамжын дагуу зарцуулсан байна. Үүнд: нохой устгал Н.нэргүйд 840.0 мянган төгрөг, нийтийн хог цэвэрлэгээний зардалд 373.3 мянган төгрөг, хүн эмнэлгийн магадланд орход материал авахад 1000.0 мянган төгрөг, төв саадны урамшуулал Ё.Маналжавд 845.0 мянган төгрөг, өвсний фондруу гэрэл татах зардалд 535.0 мянган төгрөг, хойд худгийн кабель солих зэрэгт зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.3.6-д орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна

Мал хамгаалах сангийн талаар:

Тайлант хугацаанд мал хамгаалах сангийн харилцахын эхний үлдэгдэл 5062.4 мянган төгрөг байсан ба тайлант онд 12147.0 мянган төгрөг төвлөрсөн байна. Үүнд:

Өвс тэжээлийн үнэ 8354.5 мянган төгрөг, малжуулах төслийн зээлийн төлөлт 3420.0 мянган төгрөг, хуцны үнэ 270.0 мянган төгрөг, гүйлгээний утга тодорхойгүй 105.0 мянган төгрөг тус тус орсог байна. Тайлант онд Булангаагийн тэжээлийн фондноос 15 тн хивэг авахад 2670.0 мянган төгрөг, өвсний үнэ Мөнхбаваа ХХК-д 2093 боодол 10465.0 мянган төгрөг, үржлийн хуцны үнэ 10 толгой 2500.0 мянган төгрөг, өвсний фондын манаачын урамшуулалд 300.0 мянган төгрөг МХГазрын актын барагдуулалт 330.0 мянган төгрөг нийт 16265.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын явцад өвс тэжээлийн тайлан тооцоог гаргаагүй, үржлийн хуцыг данс бүртгэлд тусгаагүй байна. Өвс тэжээлийн тооцоог сар улиралд хийж байх шаардлагатай байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар:

Сум хөгжүүлэх сан нь оны эхэнд 53467.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба санхүүгийн дэмжлэг 50000.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн ба зээл, зээлийн хүүний эргэн төлөлтөөс 49915.8 мянган төгрөг нийт 99915.9 мянган төгрөг төвлөрсөн ба 148500.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэнээс 23 иргэнд 148500.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. 2013 оны эцэст 127713.2 мянган төгрөгийн үндсэн зээлийн 4410.5 мянган төгрөгийн зээлийн хүүгийн нийт 132123.6 мянган төгрөгийн авлагатай байна. хугацаа хэтэрсэн болон найдваргүй авлага бүртгэгдээгүй байна

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Тус санд 2013 оноос эхлэн Мигамайнз ХХК 250.0 мянган төгрөг, Монгол ронтак энерги ХХК-с нөхөн сэргээлтийн барьцаа 250.0 мянган төгрөг, Баян нүүргэстэй ХХК-с нөхөн сэргээлтийн барьцаа 150.0 мянган төгрөг, Легендмайнз ХХК барьцаа 250.0 мянган төгрөг нийт 900.0 мянган төгрөг нийт 900.0 мянган төгрөг төвлөрүүлэн байршуулсан байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09-ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.22